

СЭТГЭЦИЙН ЭМГЭГИЙН УЛМААС ХҮҮХДИЙН ЭСРЭГ ОНЦ НОЦТОЙ, НИЙГЭМД АЮУЛТАЙ ҮЙЛДЭЛ ХИЙСЭН ТОХИОЛДЛЫН ЭМНЭЛЗҮЙН ЗАРИМ СУДАЛГАА

CASE SERIES OF MENTAL PATIENTS, WHO COMMITTED SERIOUS SOCIAL DANGEROUS ACT TOWARDS CHILDREN

З.ХИШИГСҮРЭН¹, Д.ОЮУНСҮРЭН², В.ГО-ВА³, Э.МИНЖМАА⁴

¹АШУУИС-ийн Анагаах ухааны сургуулийн Сэтгэцийн эрүүл мэндийн тэнхимийн эрхлэгч, АУ-ны доктор, дэд профессор

²Мөн тэнхимийн багш

³Мөн тэнхимийн магистрант

⁴Мөн тэнхимийн резидент

KHISHIGSUREN Z.¹, OYUNSUREN D.², GO WANG W.³, MINJMAA E.⁴

¹Assoc. Professor, Ph.D, Head of Department Mental Health, Mongolian National University of Medical Sciences

²Master in Medical Science, Lecturer of Department Mental Health, MNUMS

³Graduate student for Master degree, Department of Mental Health, SOM, MNUMS

⁴Graduate student, Department of Mental Health, SOM, MNUMS

Товч агуулга: Шүүхийн сэтгэц гэм судлалын шинжлэх ухаан нь эрүүгийн болон иргэний эрх зүй, үйл ажиллагаатай холбоотой хүний сэтгэцийн байдлыг судлах сэтгэцийн эмгэг судлалын нэг салбар шинжлэх ухаан юм¹. Шүүхийн сэтгэц гэм судлал нь анагаах ухааны салбарууд, тэр дундаа сэтгэцийн эмгэг судлалтай зайлшгүй холбоотой шинжлэх ухааны нарийн салбарын нэг.

Манай улсад 1947 оноос эхлэн шүүхийн сэтгэц гэм судлалын магадалгаа хийж эхэлсэн боловч 1954 оноос албан ёсны сэтгэц гэм судлалын магадалгааны комисс ажиллаж эхэлсэн гэж үздэг.

Өнөөгийн байдлаар шүүхийн сэтгэц гэм судлалын магадалгааны олон хэлбэрийг практикт ашигладаг хэдий ч тухайн хэрэгт холбогдогчийн сэтгэцийн байдал, үйлдсэн хэргийн онцлог, хавтаст хэргийн материалын бүрдэлт зэрэг олон хүчин зүйлийг харгалзан амбулаторийн хэлбэрийн магадалгаа зонхилох хувийг эзэлдэг.

Сэтгэцийн эмгэгийн улмаас нийгэмд аюултай үйлдэл хийсэн болох нь хуулийн болон анагаах ухааны шалгуураар батлагдсан, хэрэг хариуцах чадваргүй өвчтөнүүд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн хуулийн тасагт хэвтэн эмчлүүлдэг бөгөөд 1998-2007² онд хийсэн судалгаагаар хэвтэн

эмчлүүлэгчдийн олонх нь (37.8%) шизофрени болон түүний хүрээний эмгэгтэй, 2008 онд хийсэн судалгаагаар судалгаанд хамрагдагсдын 53.5% нь танхайрах, бусдын эрүүл мэнд, амь насанд халдах аюултай үйлдлийг хийсэн гэсэн тоо баримтууд байна³. Хамгийн сүүлд 2008-2013 онуудад эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээнд хамрагдсан өвчтөнүүдийн архивын материалд судалгаа хийхэд 36.4% нь шизофрени болон түүний хүрээний эмгэгтэй, 21.3% нь хий үзэгдэл дэмийрлийн хам шинжийн улмаас бусдын амь насыг хохироосон өвчтөнүүд байна³.

Дээрх удаа дараагийн судалгаанаас үзвэл эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээнд хамрагдагсдын дотор шизофрени болон бусад солиорлын улмаас бусдын амь насыг хөнөөх хэлбэрийн нийгэмд аюултай үйлдэл нилээд их байгаа нь харагдаж байна. Иймд бид эдгээр тохиолдлуудын дотроос хүүхдийн эсрэг онц хүнд, нийгэмд аюултай үйлдэл хийсэн эмнэлзүйн тохиолдлыг судлан үзсэн юм. Энэхүү судалгаа нь хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүдийг судлан тогтоох судалгааны ажлын хүрээнд хийгдэж буй ажлын нэг хэсэг юм.



МОНГОЛЫН
УЛСЫН
МЭДЭЭНИЙ
ТӨВ
МОНГОЛЫН
УЛСЫН
МЭДЭЭНИЙ
ТӨВ

Abstract: Forensic psychiatry is a branch of clinical psychiatry which is the science of studying human mental condition related to criminal and civil legal issues. Most common type of formal validations of forensic psychiatric to expertize in outpatient clinic. According to results of many surveys, most of forensic inpatients (37.8%) are mental patients with schizophrenia and schizotypal disorders. In addition, patients with paranoid syndrome usually assaulted or committed social dangerous action (53.5%) towards others' health and life. Furthermore most of patients who were admitted to involuntary forced measure killed others due to schizophrenia or other psychosis. Therefore we studied three cases of serious social dangerous acted towards children. Number of people, who should be expertizing to forensic psychiatric validation, was increased in Ulaanbaatar level since 1999. Of those, 4.38% valued as incapability. According to statistic report of National Center for Mental Health, number of inpatients, who admitted to forensic clinic, was increased in 2010-2014 years and one inpatient stayed approximately 579.3 days. Mental patients have a high risk of social dangerous act towards child. According to case series of killed children in United Kingdom, 40% of those were people with mental parents. Result of Australia shown that, each year 25 children killed in 1989-2002 years and 68% of those died due to killed by knife, other sharp object or poisoned at the age of 5 year old. Many scientists reported, that cases with schizophrenia, affective disorder, substance abuse and borderline personality disorder, were crueler mannered and a child was lost his/her life. Main method for preventing from social dangerous action due to mental disorder is to diagnose and treat under control of psychiatrist, more early. If mental patient likely be committing social dangerous action, should be involuntary admitting to forensic clinic.

Түлхүүр үгс: Хэрэг хариуцах чадваргүй байдал, шизофрени, нийгэмд аюултай үйлдэл, урьдчилан сэргийлэлт,

албадлагын арга хэмжээ.

Key words: Incapability, schizophrenia, social dangerous action, prevention, compulsory measure.

ЭМНЭЛЗҮЙН ТОХИОЛДОЛ 1.

42 настай эмэгтэй. Сэтгэцийн эмгэгийн улмаас сэтгэцийн эмнэлэгт 20 гаруй удаа хэвтэн эмчлүүлсэн. Шизофрени өвчтэй.

Өвчний түүхээс: Өвчин анх 20 орчим насанд хий үзэгдэл, дэмийрлийн шинжээр илэрсэн. Үүнээс хойш байнга сэтгэцийн эмчийн хяналтад эмчлүүлж байсан. Сүүлийн жилүүдэд сэтгэл хөдлөл бага болох, аливаад санаачлаггүй, өөрийгөө арчлах чадвар муудах зэрэг бие хүний шинжүүд тод илэрсэн. Өвчтөн өвчнийхөө улмаас өөрийгөө боомилж нас барсан.

Болсон хэрэг 1: Өвчтөн өөрийн төрсөн хүүхдийн хоолойг боож амь насыг нь хөнөөгөөд шатаасан. Өвчтөний өгүүлснээр хүүхдийнхээ эцгийг мэдэхгүй, гудамжинд явж байгаад хүнтэй танилцаад, унтаад жирэмсэн болсон. Аав, ээж маань эцэггүй хүүхэдтэй боллоо, чи өвчтэй, хүүхдийг чинь асрах хүн байхгүй гээд миний хүүхдэд дургүй байсан гэх. Тэгээд хүүхдээ хөнөөхөөд гэрийнхэндээ хүнд өргүүлсэн гээд хэлсэн.

Болсон хэрэг 2: 7 жилийн дараа өөрийн төрсөн дүүгийн хүүхэд болох 1.6 настай хүүхдийг хогийн цэг дээр аваачин хоолойг нь боож амь насыг нь хөнөөгөөд шатаасан нийгэмд аюултай үйлдлийн улмаас хуулийн тасагт хэвтэн эмчлүүлж байсан.

Нийгэмд аюултай үйлдэл хийх болсон шалтгааныг тодруулан асуухад:

Эмнэлэгт хэвтсэн үедээ хүүхдээ санаад, зүүдлээд байдаг болохоор санаанаасаа гаргах гэж алсан. Алснаас хойш зүүдэнд орохоо больсон.

Манай дүү нөхөртэйгөө маргалдаад, хүүхдээ асрахгүй гээд байдаг бас би эмнэлэгт хэвтэхдээ дүүгийнхээ хүүхдийг санадаг байсан учраас хүүхдийг нь санахаа больё гээд хогийн цэг дээр аваачаад хоолойг нь боож алаад хог



цуглуулж байгаад шатаасан. Бас би тэр хүүхдийг хайрлаж өсгөсөн хугацааныхаа хөдөлмөрийг үнэлсэн юм. Тэгээд юмаар дарж тавьчихаад хүн үхээд шатахаараа юу болдог юм бол гэж өдөр бүр очиж үздэг байсан. Тэгээд үзэх гэж явж байхдаа цагдаад баригдсан гэнэ.

“Монголын түүхэнд гарсан этгээд хачин гэмт хэргүүд” (2009, х-166-169) цуврал номонд бичсэн шүүх хурлын материалаас үзвэл: “Би эмнэлэгт хэвтэх үедээ хүүхдээ шөнө болгон зүүдлээд, санаад байсан. Тэгээд эмнэлгээс гараад хүүхдээ өрөвдөөд багалзуурдаад алчихсан. Би хүүхдэдээ маш их хайртай, өрөвдөөд хайрлаад байхаар алмаар санагдаад, алчихвал эмнэлэгт хэвтэхдээ хүүхдээ санахгүй дээ гэж бодогдоод, хайр хүрсэндээ л алсан. Жаахан хүүхэд том болоод зовох вий гэж айсандаа өрөвдөөд, зовлон үзсэнээс үхсэн нь дээр гээд 2 хүүхэд алсан” гэжээ. Уг хэргийг үйлдсэний дараа өрнөөсөө салсан хүн шиг, сэтгэл сайхан болсон, хүүхдээ санахаа больсон гээд инээнэ.

Дүгнэлт: Өвчтөн хий үзэгдэл-дэмийрлийн хэлбэрийн шизофрени өвчтэй. Шизофрени өвчний үндсэн шинжүүдийн нэг болох сэтгэл хөдлөл, сэтгэхүй хоёрдмол болох шинжийн улмаас удаа дараа бага насны хүүхдийн амь насыг хөнөөсөн. Эмнэлзүйн ярилцлагын явцад хүүхэд алсан тухайгаа ярихдаа инээх, харамсал төрөхгүй байх зэрэг тохироогүй сэтгэлийн хөдөлгөөний шинжүүд илэрч байжээ.

ЭМНЭЛЗҮЙН ТОХИОЛДОЛ 2

Хий үзэгдэл, дэмийрлийн хэлбэрийн шизофрени өвчний улмаас сэтгэцийн эмчийн хяналтад 20 гаруй жил эмчлүүлсэн эмэгтэй.

Өвчний түүхээс: Эгчийн үгээр: Залуу насандаа сэтгэлзүйн гэмтэл авсны дараа өвчин нь эхэлсэн. Өвчний улмаас сэтгэцийн эмчийн хяналтад эмчилгээ хийлгэдэг байсан. Хий харлаа гэж ярьдаг, Ганцаараа ярина, амандаа үглэнэ. Өөрийгөө арчлах болон гэр орны ажилдаа муу. Энэ хүүхдийнхээ эцгийг мэдэхгүй. Бие нь сайн байхдаа

хүүхдээ хайртай, сайн байсан гэнэ.

Болсон хэргийн товч: Өөрийн үгээр: Миний залуу, хөгшин насны дүрүүд бий болоод надтай ярьдаг байсан. Сүүлийн хэд хоногт хөгшин дүрийн хүн нь чи ядраад байвал наад хүүхдээ алчих гээд яриад байдаг болсон юм. Гэрийнхэндээ би энэ тухай хэлээгүй. Надаас хүн асуугаагүй. Би төрснийхөө дараа их ядардаг байсан. Манай хүүхэд их уйлдаг. Тэр өдөр уйлаад байхаар нь толгой руу нь сандлаар 2 цохисон чинь бас л уйлаад байхаар нь дахиад төмрөөр цохисон. Тэгсэн чинь дуугүй болохгүй уйлаад байхаар нь гал тогооноос заазуур аваад толгойных нь ар талаас заазуурдсан чинь дугарахгүй болоод цус гараад байхаар нь ванны өрөөнд авч ороод цусыг нь угааж хувцсыг нь солиод, сольсон хувцсыг нь угаагаад. Нойлын утсаар хүзүүг нь хагас оёод даавуугаар бүтээгээд тавьчихсан. Дараа нь өлгийдөөд орхисон, гэрийнхэндээ хүүхдээ түлчихсэн гэж хэлсэн гэв.

Шүүхийн шинжээч эмчийн үзлэгээр: 1-2 орчим насны хүүхэд. Нүүр, дух хэсгээр их хэмжээний зөөлөн эдийн няцралтай, толгой нь их биеэсээ салж хүзүүний өмнөд хэсгийн арьсан дээр тогтсон, шарханд нь даавууны өөдөс чихсэн байсан.

Дүгнэлт: Өвчтөн хий үзэгдэл-дэмийрлийн хэлбэрийн шизофрени өвчтэй. Өвчин дахисан үед сонсголын хий үзэгдэл, дэмийрлийн шинжүүд илэрсний улмаас өөрийн хүүхдийн амь насыг онц хэрцгий аргаар хөнөөсөн байна.

ЭМНЭЛЗҮЙН ТОХИОЛДОЛ 3

38 настай эмэгтэй, шизофрени өвчнөөр 20 орчим жил өвчилсөн. Уг өвчний улмаас сэтгэцийн эмнэлэгт хэвтэж байсан боловч эмчийн хяналтад байдаггүй.

Удамд: Өвөө нь сэтгэцийн өвчтэй хүн байсан. Яг ямар өвчтэйг нь мэдэхгүй.

Хавтаст хэргийн материалаас: Өөрийн төрсөн охиноо гүрээний баруун судас дайруулан хутгалж, мөн цээжний хөндий рүү хутгалж заазуураар толгойг нь тасалсан.

Өөрийнх нь үгээр: Өөрийн гэр орон байхгүй, айл хэсэж явдаг. Хүмүүс ад үзээд хөөж туугаад байдаг. Хүүхдээ дагуулаад гадуур тэнэдэг байсан. Тэр өдөр хүүхдээ газар хэвтүүлж байгаад хүзүү, цээж рүү нь хутгалсан чинь хүүхэд уйлаад байхаар нь хутгаа шидээд хүүхдээ цааш авч явж байгаад хүзүүгээр нь нугалсан. Тэгээд бүр гэдсийг нь задалж өвчнийг нь үзэх гэж байснаа цагдаа ирэх байх гэж айгаад өөрийнхөө гэдэс, мээм рүү хутгалсан. Тэгээд хүүхдээ бариад байж байтал цагдаа ирсэн гэх.

Дүгнэлт: Өвчтөн хий үзэгдэл, дэмийрлийн шизофрени өвчтэй. Өөрийнхөө хүүхдийг өвчтэй, хавдартай гэсэн буруу итгэл үнэмшилд автсан буюу дэмийрлийн хам шинж илэрч байсан байна.

ХЭЛЦЭМЖ

Улаанбаатар хотын хэмжээнд шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын шинжилгээг зөвхөн Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийг түшиглэн хийдэг. Шүүхийн сэтгэц гэм судлаач эмч Д.Лянхуа, Л.Баттулга, Л.Амгалан нарын хийсэн судалгаанаас үзвэл манай улсад магадалгаа хийлгэх хүмүүсийн тоо 1999 оноос хойш өсөн нэмэгдсэн ажээ. Түүнчлэн эрүүгийн хэргийн улмаас шүүхийн сэтгэц гэм судлалын магадлан шинжилгээ хийлгэсэн тохиолдлын 4.98% нь эрүүгийн хариуцлага хүлээх чадваргүй байсан байна⁴. Харин Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн статистик мэдээнээс үзвэл 2010-2014 онуудад шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникт хэвтэн эмчлүүлэгсэд сүүлийн 5 жилийн дунджаас 7 эмчлүүлэгчээр нэмэгдэн нэг өвчтөн дунджаар 579.3 хоног хэвтэн эмчлүүлсэн байна⁵. Дээрх үзүүлэлтээс үзвэл эрүүгийн хариуцлага хүлээх чадваргүй байдал нь тухайн үед өвчтөн болж буй үйл явдлыг ухамсарлан ойлгож, өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй байдалд байсантай холбоотой. Эдгээр эмнэлзүйн тохиолдлууд нь хүн амын дунд аймшигтай, хэрцгий гэмт хэрэг мэт байвч мөн чанартаа энэ нь сэтгэцийн өвчтэй хүний үйлдсэн нийгэмд аюултай

үйлдэл бөгөөд өртөгч нь хохирогч болдог сул талтай үзэгдэл юм.

СЭМ-ийн хуулийн 3.1.13-д "Сэтгэцийн эмгэгтэй хүний нийгэмд аюултай үйлдэл гэж сэтгэцийн эмгэгийн улмаас хүн өөрийгөө хянах чадваргүй болж, өөрийн буюу бусдын амь нас, нийгэмд хор хохирол учруулахыг хэлнэ" хэмээн заасан байдаг⁶.

Сэтгэцийн эмгэгийн улмаас нийгэмд аюултай үйлдэл хийсэн тохиолдлын дотор шизофрени өвчин, эмнэлзүйн хэлбэрийн хувьд хий үзэгдэл дэмийрлийн хамшинжтэй өвчтөнүүд ихэнхи хувийг эзэлдэг.

Шизофрени өвчин нь судлагдаж эхэлснээсээ хойш өнөөг хүртэл үүсэх шалтгаан нь тогтоогдоогүй, эмнэлзүйн олон хэлбэртэй, удамшилтай өвчин⁶ бөгөөд эмнэлзүйн хэлбэрүүдээс хий үзэгдэл, ялангуяа захиран тушаах хий үзэгдэл, дэмийрэл илрэх нь өвчтнийг нийгэмд аюултай үйлдэл хийх сэдэл болдог.

Хэвлэлийн тоймоос үзвэл Англи улсад хүүхдийн амь нас хөнөөсөн тохиолдлыг судлан үзэхэд 40% нь эцэг, эх нь сэтгэцийн эмгэгтэй байсан бөгөөд⁷ Австралид хийсэн судалгаагаар 1989-2002 онуудад жил бүр дунджаар 25 хүүхэд алагдсаны 68% нь 5 хүртэлх насандаа хутгалах, иртэй үзүүртэй зүйлээр хөнөөх, хордуулсны улмаас нас барсан байжээ⁸.

Сэтгэцийн эмгэгтэй хүмүүс хүүхдийн амь насыг егүүтгэхдээ тарчлаан зовоох аргыг хэрэглэх нь их байдаг⁹. Энэ нь өвчний улмаас хийж буй үйлдэлтэй нь холбоотой гэж үзэж байна.

Судлаачид сэтгэцийн эмгэгүүдээс шизофрени, сэтгэл цочирдлын эмгэг, мансууруулах бодист донтох эмгэг, бие хүний эмгэгийн улмаас нийгэмд аюултай үйлдэл, түрэмгийлэл үйлдэх эрсдэл өндөр байдаг гэж үзэж байна. Ялангуяа шизофрени тэй өвчтөнүүд хий үзэгдэл, захиран тушаах, заналхийлэх агуулгатай хий үзэгдэл, дэмийрлийн улмаас нийгэмд аюултай үйлдэл хийх эрсдэлтэй болохыг онцлон тэмдэглэжээ.

Сэтгэцийн эмгэгийн улмаас нийгэмд аюултай үйлдэл хийхээс урьдчилан



МОНГОЛЫН
ХҮҮЛЬ САХИУЛАХ
УЛСЫН
ЭРХИЙН
СЭТГЭЦИЙН
ЭМГЭГИЙН
ЭМЧЛЭХ
ЭМЧИЙН
ХЯНАЛТАД
ЭМЧЛЭХ
ХЭРЭВ
ӨВЧТӨН
НИЙГЭМД
АЮУЛТАЙ
ҮЙЛДЭЛ
ХИЙЖ
БОЛЗОШГҮЙ
БОЛ
АЛБАДАН
ЭМЧИЛГЭЭ
ХИЙХ
ШААРДЛАГАТАЙ
БӨГӨӨД
СЭТГЭЦИЙН
ЭМГЭГИЙН
УЛМААС
АЛБАДАН
ЭМЧЛЭХ
ЭМГЭГИЙН
ЖАГСААЛТЫГ
ЭРҮҮЛ
МЭНДИЙН
САЙДЫН
2015 ОНЫ
180 ТООТ
ТУШААЛД
ДЭЛГЭРЭНГҮЙ
ЗААСАН
БАЙДАГ¹⁴.

Сэтгэцийн эмгэгтэй өвчтөний нийгэмд аюултай үйлдэл хийсэн болохыг хуулийн болон анагаах ухааны шалгуураар үнэн зөв тогтоох нь сэтгэцийн өвчтөний эрхийг хамгаалах хууль зүйн чухал асуудлын нэг мөн.

НОМ ЗҮЙ

1.С.Бямбасүрэн, Ш.Доржжадамба. Шүүхийн сэтгэц гэм судлал. УБ., 1990. х 8-10

2.3.Хишигсүрэн, Л.Мөнхтуяа, С.Одонгэрэл. Сэтгэцийн өвчний улмаас бусдын амь насыг егүүтгэсэн байдалд хийсэн судалгааны үр дүн. Сэтгэцийн эрүүл мэндийн алба үүсэн байгуулагдсаны 80 жилийн ойд зориулсан илтгэл. УБ., 2009. Х 70-72

3.Л.Мөнхтуяа, О.Ганчулуун, З.Хишигсүрэн. Эмнэлгийн чанартай албадан эмчилгээнд эмчлүүлэгчдийн нийгэмд аюултай үйлдлийн хэлбэрүүд. INNOVATION. Vol. № 9, 01 сар, 2015. х 60-64

4.Л.Баттулга, Э.Амгалан, Д.Лянхуа. 2006-2013 онд хийсэн шүүхийн

сэтгэцийн эмгэг судлалын магадлан шинжилгээтэй холбоотой зарим асуудал. INNOVATION. Vol. № 9, 01 сар, 2015. х 85-86

5.Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв. Сэтгэцийн эрүүл мэндийн статистик үзүүлэлт (2010-2014). УБ., 2015. Х 31

6.Монгол улсын Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль. УБ., 2013.

7.С.Бямбасүрэн. Сэтгэцийн эмгэг судлал. УБ., 2007.

8.Parents with Mental Health Problems. Http:\www.taktent.org.uk/mental health articles. UK. 2013.

9.Jenny Mouzos, Catherine Rushforth. Family Homicide in Australia. Australian institute of criminology. № 255. June. 2003.

10. Д.Лянхуа, Т.Ганцэцэг. Сэтгэцийн өвчний улмаас гэмт хэрэг үйлдсэн эмэгтэйчүүдийн хэргийн онцлог. Сэтгэцийн эмгэгийн клиникийн эмнэл үүсэн байгуулагдсаны 75 жилийн ойн онол практикийн бага хурал. УБ., 2004. Х 100-107.

11.Alexandre Martins Valenca, Antonia EgidioNardi, Isabella Nascimento. Schizophrenia and violent behavior. Rev.Latino-am.Psicopat.Fund., San Paulo.v 14,n.4,p 660-671.Dezembro 2011.

12. Marie E. Rueve, Randon S. Welton, Violence and mental illness. May. Psychiatry 2008.

13.Эрүүл мэндийн сайдын 2014 оны 05 сарын 30-ны өдрийн 180 тоот тушаал. УБ., 2014.

**Уншиж танилцан нийтлэхийг зөвшөөрсөн:
Сэтгүүлийн зөвлөлийн гишүүн, хууль зүйн доктор,
цагдаагийн хурандаа Т.Бямбаа**